



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЪЯА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

Аудитын нэр: Талын-Илч” ОНӨААТҮГ-ын 2014-2015 оны санхүүгийн зарим үйл ажиллагааны үр дүн

2014-2015 онд ашиглалтад ороогүй үндсэн хөрөнгөнд элэгдэл байгуулж, элэгдлийн зардлыг нэмэгдүүлснээр алдагдалтай гарсан байна.



2016 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймгийн аудитын газар Тэргүүлэх аудитор Ш.Ичинхорлоо Аудитын менежер Б.Сарантуяа Ахлах аудитор Ц.Батсайхан 2016 оны 11 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151 дугаарын утас, 7054- 3179 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 217 тоот	Товчилсон үгийн тайлбар4 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5 БҮЛЭГ1: Байгууллагын үйл ажиллагааны орлогыг үнэн зөв төлөвлөөгүй, сум орон нутгийн удирдлагаар орлогын төлөвлөгөөгөө батлуулж ажиллаагүй байна. 1.1 2014-2015 онд тус байгууллагын удирдлага аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулж ажиллаагүй байна. 1.2 2014-2015 онд үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 22.0-24.0 хувиар давуулан биелүүлсэн байна. 1.3 Үйл ажиллагааны орлогыг нэр төрлөөр нь үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байна. БҮЛЭГ 2: Үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн байна. 2.1 2014-2015 онд зарим зардлын үндэслэлгүйгээр 70.0-85.2 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн ба үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж ажиллаагүй байна. 2.2 2015 оны ББӨ-т 29,957.1 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардлыг буруу бүртгэж, тайлагнасан байна. 2.3 2014-2015 онд нийт 10,864.9 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй зардал гаргасан байна. БҮЛЭГ 3: Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа болон элэгдлийг үнэн зөв тоцоогүй байна 3.1. Үндсэн хөрөнгийн ашиглах хугацааг үндэслэлгүй тооцсон байна. 3.2. Ашиглагдаагүй үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцсон байна. 3.3. Үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ эрх бүхий байгууллагын зөвшөөрөл аваагүй байна 3.4. Үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зохих журмын дагуу байна БҮЛЭГ 4: Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтгүй байна. 4.1. Байгууллагын удирдлагаас тавих хяналт хангалтгүй байгаагаас авлага 2015 онд авлага өмнөх оноос 4.7 дахин, өглөг 1.7 дахин өссөн байна.
--	--

	4.2. Байгууллагын 2015 онд ашиг, алдагдыг буруу тооцсон байна. 4.3. Байгууллагын удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна. Дүгнэлт..... Зөвлөмж..... Холбогдох байгууллагын санал:..... Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал Саналд өгсөн тайлбар Хавсралтууд
--	--

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитын зорилго:

Баянтал сумын “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын 2014-2015 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж дүгнэлт гарган, үр өгөөжийг дээшлүүлэх талаар зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

Аудитын хамрах хүрээ:

Баянтал сумын “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын 2014-2015 оны үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө, үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан тэнцэл болон анхан шатны баримт холбогдох бусад баримт материалыг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, харьцуулан шинжлэх, түүвэрчлэн шалгах зэрэг сорил, горимуудыг хэрэгжүүлэн эрсдэлийг илрүүлж, үнэлэх зэрэг аудитын арга зүйг ашиглан нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. /Асуудлын шинжилгээ, арга зүйг хавсралт №2, 3-аас үзнэ үү/

Үндсэн мэдээлэл:

Баянтал сумын “Талын-Илч” ОНӨААТҮГ нь 1991 оны 8 дугаар сард аймгийн Эрчим хүчний харьяанд байгуулагдаж, халаалт, халуун, хүйтэн ус түгээж, бохир усыг татан зайлуулах, орон сууцны засвар үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд 1999 онд “Талын-Илч” улсын үйлдвэрийн газар нэртэйгээр бие даасан аж ахуйн нэгж, 2005 оноос “Талын-Илч” ОНӨААТҮГ нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус байгууллага нийт 13 орон тоотой ажиллаж байна. Үүнээс Захирал 1, нягтлан бодогч 1, борлуулалтын байцаагч-нярав 1, зуухны инженер 1, жолооч 1, Бохир цуглуулах худгийн засварчин 1, гагнуурчин 1, худгийн оператор 1, зуухны сахиул засварчин 1, машинист 4 байна.

Сумын хэмжээнд 6 төсөвт байгууллага, 6 аж ахуйн нэгж байгууллага, 140 айл өрхөд ажил үйлчилгээ үзүүлж байна.

2014 оны санхүүгийн тайлангаар 180,144.4 мянган төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлж, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 155,965.7 мянга, удирдлагын

зардалд 51,439.9 мянга, нийт 207,405.6 мянган төгрөгийг зарцуулж, 27,261.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2015 оны санхүүгийн тайлангаар борлуулалтын орлого 255,243.8 мянга, бусад орлого 1,650.0 мянга, нийт 256,893.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 201,748.4 мянган төгрөг, удирдлагын зардал 69,535.7 мянга, нийт 271,284.1 мянган төгрөгийг зарцуулж, 14,390.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Байгууллагын үйл ажиллагааны орлогыг үнэн зөв төлөвлөж, батлуулсан эсэх

Бүлэг 1

Байгууллагын үйл ажиллагааны орлогыг үнэн зөв төлөвлөөгүй, сум орон нутгийн удирдлагаар орлогын төлөвлөгөөгөө батлуулж ажиллаагүй байна.

1.1. 2014-2015 онд тус байгууллагын удирдлага аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулж ажиллаагүй байна.

“Талын илч” ОНӨААТҮГ-ын дарга 2014-2015 онд аймаг, сумын Засаг дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулан, тухайн тайлант жилийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулж ажиллаагүй ба 2016 онд гурвалсан гэрээ байгуулсан боловч төлөвлөгөөгөө батлуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-д “орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэснийг зөрчсөн байна.

Иймд жил бүрийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулан, мөрдөж ажиллах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

1.2. 2014-2015 онд үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 22.0-24.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Баянтал сумын “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын үндсэн үйл ажиллагааны орлого нь дараах орлогуудаас бүрдэж байна. Үүнд:

- Дулаан, халаалтын орлого
- Цэвэр ус бэлтгэж түгээлтийн орлого
- Бохир ус татан зайлуулах орлогуудаас бүрдэж байна.

Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагааны орлогыг 2014 онд 145,220.2 мянга, 2015 онд 210,320.2 мянган төгрөгөөр тус тус төлөвлөсөн бөгөөд орлогоо 2014 онд 180,144.4 мянга, 2015 онд 256,893.4 мянган төгрөгөөр бүрдүүлж, орлогын

төлөвлөгөөгөө 2014 онд 24.0 хувиар, 2015 онд 22.0 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.


Дээрх онуудад үйлдвэрлэл, үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн нь сайшаалтай ч байгууллагын үйл ажиллагааны нөөц, бололцоо боломжийг дайчлан орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөж ажиллаагүй гэх үндэслэлтэй байна. Мөн үйл ажиллагааны бус зарим орлогуудыг орлогын төлөвлөгөөнд тусгаж ажиллаагүй байна. Тухайлбал 2014 онд үндсэн үйл ажиллагааны бус орлого буюу цахилгааны орлого, засвар үйлчилгээний орлого, түрээсийн орлого, техникийн нөхцлийн орлого, бусад орлого зэрэг 5,338.9 мянга, 2015 онд 16,273.3 мянган төгрөгийн орлогууд төлөвлөсөн орлогоос гадуур орсон байна.

2013-2015 оны орлогын төлөвлөгөөний харьцуулалтын судалгааг хүснэгтээр харуулбал:

						/мян.төг/
№	Орлогын төрөл	2013 он	2014 он	2015 он	Зөрүү	Хувь
1	Халаалтын орлого	-	138,719.0	203,819.0	65,100.0	46.9
2	Цэвэр усны орлого	-	4,348.4	4,348.4	0.0	0.0
3	Бохир усны орлого	-	2,152.8	2,152.8	0.0	0.0
4	Нийт дүн		145,220.2	210,320.2	65,100.0	46.9

Хүснэгтээс харахад: 2013 онд үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүй бөгөөд 2015 онд халаалтын орлогыг өмнөх оноос 65,100.0 мянган төгрөг буюу 46.9 хувиар өсгөж төлөвлөсөн байна. Энэ нь аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2014 оны 11 дүгээр тогтоолоор халаалтын мөрдөж байсан үнэ, тарифыг өөрчилж, Төсвийн байгууллагын халаалтын үнийг 47.3 хувь, айл өрхийн халаалтын үнийг 60.0 хувиар тус тус нэмсэн боловч тус байгууллагын халаалтын орлогыг 46.9 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

2014-2015 онд тус байгууллагын үйлдэрлэл, үйл ажиллагааны үр ашиг, үр дүн болон орлогын төлөвлөгөөний биелэлтэд аймаг, сумын ИТХ болон Засаг дарга нарын зүгээс хуулиар хүлээсэн эрх үүргийн дагуу үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөг нь баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж, үр дүнгийн гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна. 2014-2015 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний биелэлтийг графикаар харуулбал:



Графикаас харахад: 2015 онд орлогын төлөвлөгөөг өмнөх оныхоос 46,9 хувь буюу 65,100.0 мянган төгрөгөөр тус тус өсгөж төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр орлогын төлөвлөгөөг 2014 онд 24.0 хувь буюу 34,924.2 мянга, 2015 онд 22.0 хувь буюу 46,573.5 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Үүнээс үзэхэд жил бүр орлогын төлөвлөгөө нь нэмэгдэн батлагдаж байгаа боловч орлогын төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлсэн нь орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүй, үндсэн үйл ажиллагааны орлогоос гадна олж буй бусад орлогыг төлөвлөөгүйтэй холбоотой байна. Тухайлбал: 2015 онд ААНБ-дын халаатын үнийн тарифыг 47.3 хувь, айл өрхийн халаатын үнийг 60.0 хувиар тус тус нэмсэн боловч халаалтын орлогын төлөвлөгөөг 46,9 хувиар өсгөж төлөвлөсөн бөгөөд айл өрхийн халаалтын үнийн нэмэгдлийг 13.1 хувиар дутуу төлөвлөсөн байна.

1.3. Үйл ажиллагааны орлогыг нэр төрлөөр нь үнэн зөв бүртгэж, тайлагнаагүй байна.


Баянтал сумын “Талын-Илч” ОНӨААТҮГ нь 2014 онд 180,444.4 мянга, 2015 онд 256,893.7 мянган төгрөгийн орлогыг тус тус бүртгэж, тухайн тайлант оны орлогыг нийт дүнгээр нь бүрэн бүртгэсэн боловч орлогын нэр төрлийг дутуу ангилж бүртгэсэн байна.

2014-2015 оны орлогын нэр төрлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/				
№	Орлогын төрөл	2014 он	2015 он	Зөрүү
1	Халаалтын орлого	161,713.1	230,800.9	69,087.8
2	Цэвэр усны орлого	10,856.5	6,452.2	-4,404.3
3	Бохир усны орлого	2,235.9	3,367.3	1,131.4
4	Цахилгааны орлого	2,557.4	3,050.7	493.3
5	Материалын орлого	152.7	1,884.6	1,731.9
6	Засвар үйлчилгээний орлого	1,179.3	1,000.8	-178.5
7	Түрээсийн орлого	1,404.0	9,829.0	8,425.0
8	Техникийн нөхцлийн орлого	45.5	227.3	181.8
9	Бусад орлого		266.3	266.3
10	Хүүгийн орлого		14.6	14.6
	Нийт дүн	180,144.4	256,893.7	65,814.9

Хүснэгтээс харахад: Жил бүр орлогын төлөвлөгөөг зөвхөн үндсэн үйл ажиллагааны 3 төрлийн орлогоос гадна 2014 онд 5 төрлийн 34,924.2 мянга, 2015 онд 7 төрлийн 48,573.5 мянга, нийт 83,497.7 мянган төгрөгийн орлого илүү төвлөрүүлсэн байна.

2014-2015 оны орлогын бүтцийг диаграмаар харуулбал:



Диаграмаас харахад: 2014 онд нийт орлогын 90 хувийг халаалтын орлого, 6 хувийг цэвэр усны орлого, 1 хувийг бохир усны орлого, 1 хувийг цахилгааны орлого, 1 хувийг засвар үйлчилгээний орлого, 1 хувийг түрээсийн орлогоос тус тус бүрдсэн байна.

2015 онд нийт орлогын 90 хувийг халаалтын орлого, 3 хувийг цэвэр усны орлого, 1 хувийг бохир усны орлого, 1 хувийг цахилгааны орлого, 1 хувийг материалын орлого, 4 хувийг түрээсийн орлогоос тус тус бүрдсэн байна.

2014-2015 онд тус байгууллага нь тээврийн хэрэгслээ түрээслүүлэх, мөн ажил үйлчилгээний чиглэлээр бусад ААНБ-д засвар үйлчилгээ хийх зэргээр нэмэлт орлого олсон байна.

Нэмэлт орлогуудыг нэр төрлөөр нь бүртгэж тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д “Бүх орлогыг заавал тусгана гэснийг” зөрчсөн байна.

Иймд байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан бодит тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн орлогыг боломжит хэмжээ, нэр төрлөөр нь төлөвлөн батлуулж, биелэлтийг нь хангаж ажиллах, мөн орлогыг нэр төрлөөр нь үнэн зөв бүртгэж тайлагнаж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Зардлын төлөвлөгөөг батлуулж, зарцуулалтыг үнэн зөв тооцож, бүртгэсэн үү ?

Бүлэг 2

Үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг үндэслэлгүй төлөвлөсөн байна.

2.1 2014-2015 онд зарим зардлыг үндэслэлгүйгээр 70.0-85.2 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн ба үйл ажиллагааны зардлын төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж ажиллаагүй байна.

2014-2015 онд аймаг, сумын Засаг дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулж, үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулж ажиллаагүйгээс зарим зардлыг өмнөх оныхоос үндэслэлгүйгээр өсгөн төлөвлөж, алдагдалтай ажиллах нөхцлийг бий болгосон байна. Тухайлбал: 2015 онд өмнөх оныхоос нүүрсний зардлыг 85.2 хувь, тээврийн зардлыг 74.6 хувь, цахилгааны зардлыг 70.9 хувиар тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Гэтэл 2015 онд нүүрсний болон шатахууны үнэ нэмэгдээгүй, тогтвортой байсан бөгөөд уг зардлууд өсөх шалтгаан байхгүй байна.

Харин 2013 онд зардлыг төлөвлөж ажиллаагүйгээс 2014 оны зардлыг өмнөх онтой харьцуулж, дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

Тус байгууллага нь үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардалд 2014 онд 267,699.4 мянга, 2015 онд 324,956.5 мянган төгрөгийг тус тус зарцуулахаар төлөвлөсөн байна.

Зардлын төлөвлөгөөг нэр төрлөөр хүснэгтээр харуулбал.


/мян.төг/

Зардлын нэр		2014 он	2015 он	Зөрүү
1	Цалингийн зардал	97,929.2	84,804.0	(13,125.2)
2	НДШимтгэлийн зардал	12,730.8	11,024.5	(1,706.3)
3	Цахилгааны зардал	26,620.0	45,500.0	18,880.0
4	Нүүрсний зардал	45,891.4	85,000.0	39,108.6
5	Нүүрс тээврийн зардал	18,900.0	33,000.0	14,100.0
6	Шатахууны зардал	6,300.0	6,300.0	-
7	Хоолны зардал	500.0	500.0	-
8	Холбооны зардал	1,294.0	1,294.0	-
9	Бичиг хэргийн зардал	270.0	270.0	-
10	Хөд.хамгаалалын зардал	3,750.0	3,750.0	-
11	Материалын зардал	5,600.0	5,600.0	-
12	ҮХХАТатварын зардал	600.0	600.0	-
13	Ус рашаан ашигласны төлбөр	288.0	288.0	-
14	ҮХ-н элэгдэл	41,346.0	41,346.0	-
15	Засвар.үйл	4,230.0	4,230.0	-
16	Бусад	1,450.0	1,450.0	-
Нийт дүн		267,699.4	324,956.5	57,257.1

Хүснэгтээс харахад : 2015 онд өмнөх оноос ажилчдын цалинг 13.125.2 мянга, НДШ-ийн зардлыг 1,706.3 мянга, нийт 14,831.5 мянган төгрөгөөр бууруулсан нь гэрээт ажлын хөлс болон шагнал урамшууллын зардлыг төлөвлөөгүй байна.

Харин цахилгааны зардлыг 18,880.0 мянга, нүүрсний зардлыг 39,108.6 мянга, нүүрс тээврийн зардлыг 14,100.0 мянга, нийт 72,088.6 мянган төгрөгөөр зардлыг нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Орлого, зардлын төлөвлөгөөг графикаар харуулбал:



Графикаас харахад: 2014 онд 145,200.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 267,699.4 мянган төгрөгийн зардал гаргаж, 122,479.2 мянган төгрөгийн алдагдалтай, 2015 онд 210,320.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 324,956.5 мянган төгрөгийн зардал гаргаж, 114,636.3 мянган төгрөгийн алдагдалтай тус тус ажиллахаар төлөвлөсөн байна.

Тус байгууллага нь жил бүр алдагдалтай ажиллахаар тооцоолсон нь орлого олох боломжит нөөц бололцоогоо дайчлаагүй, байгууллагын үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллаагүйгээс гадна нүүрсний үнэ болон тээврийн хөлс, цахилгааны зардлыг үндэслэлгүйгээр өсгөн тооцоолж, алдагдалтай ажиллахаар төлөвлөсөнтөй холбоотой байна.

Тухайлбал: 2015 онд нүүрсний үнийг өмнөх оныхоос 85.2 хувь буюу 39,108.6 мянга, цахилгааны үнийг 70.9 хувь буюу 18,880.0 мянга, тээврийн хөлсийг 74.6 хувь буюу 14,100.0 мянган төгрөгөөр тус тус өсгөн нийт 72,088.6 мянган төгрөгийн зардлыг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн төлөвлөсөн ба эдгээр нэмэгдэл нь нийт алдагдлын 62.9 хувийг эзлэж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.2 2015 оны ББӨ-т 29,957.1 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардлыг буруу бүртгэж, тайлагнасан байна.

Баянтал сумын “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын захирлын тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 6 дугаар зүйлийн 6.13-д “Зардлын бүртгэлийн бодлого, горимд ББӨ-ийг өртөг, зардлыг нэр төрөл тус бүрээр нь өртгийн төвөөр нээж бүртгэнэ, “Шууд бус зардлыг “Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал” гэсэн дансанд хуримтлуулна”, “Тайлангийн хугацааны эцэст ҮНЗ дансыг “Дуусаагүй үйлдвэрлэл данс руу хаана” гэж тусгасан боловч дээрх дансуудыг нээж бүртгээгүй, ажил гүйлгээ гарсан тухай бүрд нь ажил гүйлгээний онцлог аль зардалд хамаарахаас нь шалтгаалж зардлыг ББӨ, борлуулалт маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал, бусад зардал гэсэн 4 зардлын дансанд хуримтлуулан бүртгэж, тайлагнасан байна.

2014 оны санхүүгийн тайлангаар борлуулалтын орлого 180,144.4 мянган төгрөг, ББӨ 155,965.7 мянга, үйл ажиллагааны зардал 51,439.9 мянга нийт 207,405.6 мянган төгрөгийн зардал гаргаж, 27,261.2 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Нийт алдагдлын 75.0 хувийг ББӨ, 25.0 хувийг үйл ажиллагааны зардал эзэлж байна.

2015 оны санхүүгийн тайлангаар борлуулалтын орлого 256,893.7 мянган төгрөг, ББӨ 201,748.4 мянга, үйл ажиллагааны зардал 69,535.8 мянга, нийт 271,284.2 мянган төгрөгийн зардал гаргаж, 14,390.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Нийт алдагдлын 79.0 хувийг ББӨ, 21.0 хувийг үйл ажиллагааны зардал эзэлж байна.

2013-2015 оны Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн судалгааг хүснэгтээр харуулбал.

Д/д	Зардлын төрөл	2013 он	2014 он	2015 он	2014 оны өөрчлөлт	2015 оны өөрчлөлт
1	Цалин-дулаан	33,150.7	30,615.00	34,796.20	-2,535.70	4,181.20
2	Цалин-Цэвэр ус	2,652.7	1,824.80	4,028.30	-827.90	2,203.50
3	Цалин бохир	1,522.3	1,322.70	5,236.60	-199.60	3,913.90
4	НДШ-Дулаан	4,277.3	4,044.80	4,723.20	-232.50	678.40
5	Эм-НДШ -Цэвэр ус	301.5	426.60	523.60	125.10	97.00
6	ЭМ-НДШ-Бохир ус	197.9	171.90	680.70	-26.00	508.80
7	Материалын зардал	271.9	2,346.10	4,466.80	2,074.20	2,120.70
8	Материалын зардал-дулаан	3,428.2	3,616.20	8,150.50	188.00	4,534.30
9	Цэвэр ус -Орон сууцны материал	362.6	1,328.10	851.90	965.50	-476.20
10	Бохир-материалын зардал	79.1	319.80	437.80	240.70	118.00
11	Шатахууны зардал-Дулаан	4,878.0	4,153.30	11,743.10	-724.70	7,589.80
12	Нүүрсний зарцуулалт	28,101.2	39,487.10	43,837.60	11,385.90	4,350.50
13	Бичиг хэргийн зардал	512.2	1,353.70	1,063.80	841.50	-289.90
14	Тээврийн зардал	0.0	3,199.00		3,199.00	-3,199.00
15	Тээврийн зардал-дулаан	13,347.2	19,093.30	11,653.80	5,746.10	-7,439.50
16	Цахилгааны зардал	0.0	2,871.50	4,126.70	2,871.50	1,255.20
17	Цахилгаан -дулаан	9,491.0	4,956.90	7,659.20	-4,534.10	2,702.30
18	Цахилгаан цэвэр ус	4,604.5	7,281.70	4,251.60	2,677.20	-3,030.10
19	Цахилгааны зардал-Бохир ус	79.2	161.20		82.00	-161.20
20	Холбооны зардал	213.1	673.80	1,260.10	460.70	586.30
21	Шагнал урамшуулал-дцлаан	160.0	100.00		-60.00	-100.00
22	Элэгдлийн зардал-Дулаан	9,379.0	9,475.50	33,954.20	96.50	24,478.70
23	Элэгдэлийн зардал-Цэвэр ус	10,432.9	10,432.90	10,432.90	0.00	0.00
24	Элэгдэлийн зардал-Бохир ус	5,972.4	5,971.30	5,971.30	-1.10	0.00
25	Элэгдэлийн зардал-ТАА	498.4	498.40	498.40	0.00	0.00
26	Томилолтын зардал-Дулаан	288.9	240.10	1,046.50	-48.80	806.40
27	Хөдөлмөр хамгааллын зардал	19.0		152.50	-19.00	152.50
28	Хөдөлмөр хамгаалал	231.9		201.10	-231.90	201.10
29	Буцалтгүй тусламж	200.0			-200.00	0.00
30	Ажил олгогчын тэтгэмж	54.7			-54.70	0.00
31	Цэвэр усны зардал	22.8			-22.80	0.00
32	Нүүрсний хөнгөлөлт	147.0			-147.00	0.00
33	Сэлбэг хэрэгсэл	14.4			-14.40	0.00
34	Сэлбэг хэрэгсэл-дулаан	1,084.4			-1,084.40	0.00
35	Сэлбэг хэрэгсэл	50.1			-50.10	0.00
36	Сэлбэг хэрэгсэл бохир	22.6			-22.60	0.00
37	Нийт дүн	136,049.1	155,965.7	201,748.4	19,916.60	45,782.70

Дээрх хүснэгтээс харахад: 2014 онд 26 төрлийн 155,965.7 мянга, 2015 онд 28 төрлийн 201,748.4 мянган төгрөгийн зардлыг тус тус ББӨ-т тооцсон байна. 2014 онд

ББӨ өмнөх оноос 19,916.6 мянган төгрөгөөр буюу 14.7 хувиар, 2015 онд 45,782.7 мянган төгрөг буюу 29 хувиар тус тус өссөн байна.

Мөн 2013-2015 онд ашиглагдаагүй үндсэн хөрөнгөнд /гадна цэвэр болон бохир усны шугам/ элэгдэл тооцсоноос элэгдлийн зардал 24,478.7 мянга, бичиг хэргийн зардал 2,929.7 мянга, холбооны зардал 2,147.0 мянга, тэтгэмж урамшууллын зардал 401.7 мянга төгрөг, нийт 29,957.1 мянган төгрөгийг ББӨ-т буруу тооцоолон бүртгэж, ББӨ-ийг бодит бусаар өсгөсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”, 16 дугаар зүйлийн 16.5.6-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах” гэснийг тус тус зөрчсөн байна. Иймд:

1. Үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үнэн зөв тооцоолж байх,

2. Байгууллагын НББББ-т үйлдвэрлэл, үйл ажиллагааны болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, зардлыг холбогдох стандарт, журам, зааврын дагуу тооцох аргачлалын талаар нэмэлт өөрчлөлт оруулах зөвлөмж,

3. ББӨ-т оруулан тооцож өртгийг бодит бусаар өсгөсөн дээр дурдсан 3 төрлийн 29,957.1 мянган төгрөгийн зардлыг 2016 оны санхүүгийн тайланд тэнцэлд залруулах албан шаардлага өгөхөөр тус тус шийдвэрлэв.

2.3 2014-2015 онд нийт 10,864.9 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй зардал гаргасан байна.

Тус байгууллага нь 2014 онд 267,699.4 мянган төгрөгийн зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 202,696.0 мянга, 2015 онд 324,956.5 мянган төгрөгийн зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 254,769.3 мянган төгрөгийн зардал тус тус гаргасан байна.

Тус онуудад төлөвлөсөн зардлаа 21.6-24.5 хувиар хэмнэж ажилласан боловч уг хэмнэлт зарим зардлыг хэт өндөр төлөвлөсөнтэй холбоотой байна. Тухайлбал: 2014 онд цалин, хөлстөй холбоотой зардлыг 39.1 хувь буюу 43,239.4 мянга, 2015 онд 10.7 хувь буюу 10,261.1 мянган төгрөгөөр тус тус илүү, мөн цахилгааны зардлыг 2014 онд 11,347.9 мянга, 2015 онд 29,463.5 мянга, нүүрсний зардлыг 2014 онд 6,404.3 мянга, 2015 онд 48.4 хувь буюу 41,162.4 мянга, тээврийн зардлыг 2015 онд 64.4 хувь буюу 21,346.2 мянган төгрөгөөр тус тус илүү төлөвлөсөн байна.

2014-2015 оны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгааг хүснэгтээр харуулбал /мян.төг/


Д/д	Зардлын нэр	2014 он			2015 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин	97,929.2	59,327.9	38,601.3	84,804.0	75,606.9	9,197.1

2	НДШимтгэл	12730.8	8,092.7	4,638.1	11024.5	9,960.5	1,064.0
3	Цахилгаан	26,620.0	15,272.1	11,347.9	45,500.0	16,036.5	29,463.5
4	Нүүрс	45,891.4	39,487.1	6,404.3	85,000.0	43,837.6	41,162.4
5	Нүүрс тээврийн зардал	18,900.0	22,487.2	(3,587.2)	33,000.0	11,653.8	21,346.2
6	Шатахуун	6,300.0	4,153.4	2,146.6	6,300.0	11,743.1	(5,443.1)
7	Хоол	500.0	376.5	123.5	500.0	100.0	400.0
8	Холбоо	1,294.0	999.6	294.4	1,294.0	1,366.6	(72.6)
9	Бичиг хэрэг	270.0	1,410.9	(1,140.9)	270.0	1,063.8	(793.8)
10	Хөд.хамгаалал	3,750.0	60.0	3,690.0	3,750.0	453.6	3,296.4
11	Материал	5600	7,610.3	(2,010.3)	5,600.0	13,907.0	(8,307.0)
12	ҮХХАТатвар	600.0	540.1	59.9	600.0	540.9	59.1
13	УРА-ны төлбөр	288.0	268.6	19.4	288.0	250.0	38.0
14	ҮХ-н элэгдэл	41,346.0	41,514.0	(168.0)	41,346.0	66,039.4	(24,693.4)
15	Засвар.үйл	4,230.0	995.6	3,234.4	4,230.0	1,831.3	2,398.7
16	Бусад	1,450.0	100.0	1,350.0	1,450.0	378.3	1,071.7
Нийт дүн		267,699.4	202,696.0	65,003.4	324,956.5	254,769.3	70,187.2

Дээрх хүснэгтээс харахад: Жил бүр үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардлыг өмнөх оноос өсгөж төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр гарч буй зардал төлөвлөснөөс бага байна. Үйл ажиллагааны зардлыг 2014 онд 65,003.4 мянга, 2015 онд 70,187.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан нь бодит бус хэмнэлт бөгөөд зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр өндөр дүнгээр төлөвлөсөнтэй холбоотой байна.

Үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг графикаар харуулбал

Үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл



Графикаас харахад : Үйлдвэрлэл болон үйл ажиллагааны зардлыг жил бүр үндэслэлгүй, өндөр дүнгээр төлөвлөсөн байна

Мөн зарим үйл ажиллагааны зардлыг төлөвлөөнд тусгаж өгөөгүйгээс 2014 онд 4,709.6 мянга, 2015 онд 6,155.3 мянга, нийт 10,864.9 мянган төгрөгийн төлөвлөгдөөгүй зардал гаргасан байна

2014-2015 онуудад төлөвлөгдөөгүй зардлуудыг нэр төрлөөр нь харуулбал:
/мян.төг/

Д/д	Зардлын төрөл	2014 он	2015 он
1	Томилолтын зардал	648.1	1,461.0
2	БҮШимтгэл	69.4	69.3
3	Түрээсийн зардал	681.0	908.0
4	Сургалтын зардал	235.0	
5	Тэтгэмжийн зардал	1,408.8	902.0
6	ЭХЗЗ-н үйлчилгээний төлбөр	100.0	250.0
7	Аудитын төлбөр	850.0	1,540.0
8	Хогний төлбөр	150.0	600.0
9	Усны шинжилгээний төлбөр	41.5	27.0
10	Газрын төлбөр	167.2	100.8
11	Даатгалын зардал	258.6	190.7
12	Агаар/б татвар		21.5
13	Зам ашиглалтын татвар		22.0
14	АТБӨЯХТатвар		63.0
15	Шагнал урамшуулал	100.0	
Нийт дүн		4,709.6	6,155.3

Дээрх хүснэгтээс харахад: 2014-2015 онд зардлын төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 10,864.9 мянган төгрөгийг зардлыг гаргасан нь зардлын төлөвлөгөөг үндэслэлгүй, өмнөх жилийн гүйцэтгэл болон бодит тоо мэдээнд үндэслэн төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Иймд зардлыг төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан, бодит тоо мэдээнд үндэслэн үнэн зөв төлөвлөж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, хөрөнгийн элэгдлийг хууль тогтоомжийн дагуу үнэн зөв тооцсон эсэх

Бүлэг 3

Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа болон элэгдлийг үнэн зөв тооцож, бүртгэж тайлагнаагүй байна.

3.1 Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг буруу тооцсон байна.

Баянтал сумын “Талын-Илч” ОНӨААТҮГ-т 2014 онд 76 нэр төрлийн 1,664,171.6 мянган төгрөгийн, 2015 онд 70 нэр төрлийн 1,811,590.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

2015 онд үндсэн хөрөнгө өмнөх оноос 187,430.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь сумын ОНХС болон сумын ЗДТГ-гаас үнэ төлбөргүй хүлээн авсан 5 төрлийн 186,291.9 мянга, өөрийн хөрөнгөөр 4 төрлийн 1,138.7 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус бэлтгэсэн байна.

2014-2015 онд үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолын дагуу тооцсон байна.

Тус байгууллага нь НББ-ийн үйл ажиллагаанд санхүүгийн програмыг 2012 оны 07 сарын 14-нөөс эхлэн ашиглаж эхэлсэн бөгөөд програмд үндсэн хөрөнгүүдийг бүртгэхдээ анх ашиглалтад орсон хугацаагаар бүртгээгүй, тухайн өдрөөс ашиглаж эхэлснээр оруулснаас үндсэн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа буруу тооцогдсон байна.

Мөн 2014 онд худалдаж авсан 15 тонны усны нөөц савны ашиглалтын хугацааг 2 жилээр буруу тооцож, бүртгэсэн байна. Эдгээр нь Засгийн газрын 233 дугаар тогтоолоор баталсан үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа тооцох журмыг зөрчсөн тул хөрөнгийн ашиглалтын хугацааг үнэн зөв тооцож, элэгдлийг нь байгуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2 Ашиглагдаагүй үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцсон байна.

Тус газрын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 6.6-д “Үндсэн хөрөнгийн бодлого, горимд үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээг Засгийн газрын 2005 оны 233 дугаар тогтоолоор баталсан үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журмаар тооцно” гэсэн боловч үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох хугацаа, жилд байгуулах элэгдлийн хувийг нь татварын зорилгоор тооцохоор оруулж баталсан байна.

Тус байгууллага нь 2014 онд 69 нэр төрлийн үндсэн хөрөнгөд 41,514.0 мянга, 2015 онд 65 нэр төрлийн үндсэн хөрөнгөд 66,038.3 мянган төгрөгийн элэгдлийг тус тус байгуулсан байна.

“Талын-Илч” ОНӨААТҮГ-т 2016 оны байдлаар ашиглалтын хугацаа дууссан 4 төрлийн 7,715.0 мянган төгрөгийн хөрөнгө ашиглагдаж байгаа боловч уг хөрөнгийн ашиглалтын хугацааг нь тогтоож, дахин үнэлгээ хийгээгүй байна. Иймд дээрх хөрөнгүүдийн дахин үнэлгээ хийж, элэгдлийг байгуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Мөн үндсэн хөрөнгийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 83.3 мянган төгрөгийн барилга, 2015 онд ашиглагдаагүй 26,829.8 мянган төгрөгийн өртөгтөй гадна инженерийн цэвэр, бохирын шугамд тус тус элэгдэл байгуулан, нийт 26,913.1 мянган төгрөгийн элэгдлийг илүү байгуулсан байна.

Энэ нь санхүүгийн тайлан баланс буруу илэрхийлэгдэх, ББӨ-ийг бодит бусаар өсгөх эрсдэлүүдийг бий болгосон байна.

Иймд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд илүү тооцсон элэгдлийн зардлыг залруулах үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, байгуулах элэгдлийн хувь хэмжээг тогтоож, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу элэгдлийг үнэн зөв тооцох зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.3 Үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ эрх бүхий байгууллагын зөвшөөрөл аваагүй байна

2014-2015 онд үндсэн хөрөнгө нийт 660,608.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс 11 төрлийн 8,780.8 мянган төгрөгийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр худалдан авч, 651,828.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Тус байгууллага өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 8,780.8 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, данс бүртгэлд тусгахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3-д “Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү иргэдийн Төлөөлөгчдийн хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ” гэснийг зөрчсөн байна.

Иймд үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авч байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгэж, тооцоог нь бодсон ба тооллогоор хөрөнгө дутагдаагүй байна.

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тус зөвлөл нь хөрөнгийн өөрчлөлт хөдөлгөөнтэй хобогдох асуудлыг шийдвэрлэж холбогдох дүгнэлтийг гаргаж ажилласан байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт оновчтой зохион байгуулагдсан үү ?

Бүлэг 4

Санхүүгийн үйл ажиллагаанд удирдлагаас тавих дотоод хяналт хангалтгүй байна.

4.1. Байгууллагын удирдлагаас тавих хяналт хангалтгүй байгаагаас авлага 2015 онд авлага өмнөх оноос 4.7 дахин, өглөг 1.7 дахин өссөн байна.

Тус байгууллага нь 2014 онд 18,090.2 мянган төгрөгийн авлагатай, 19,988.1 мянган төгрөгийн өглөгтэй, 2015 онд 84,848.1 мянган төгрөгийн авлагатай, 34,758.4 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

2014 онд авлага өмнөх оныхоос 11,767.7 мянган төгрөг буюу 186 хувь, 2015 онд өмнөх оныхоос 66,757.9 мянган төгрөг буюу 4.7 дахин өссөн, өглөг 2014 онд өмнөх оныхоос 9,314.7 мянган төгрөг буюу 87,2 хувь, 2015 онд өмнөх оныхоос 14,770.3 мянган төгрөг буюу 1.7 дахин өссөн байна

2014 онд нийт авлагын 74.7 хувь буюу 13,519.6 мянга, 2015 онд 90.8 хувь буюу 77,023.0 мянган төгрөгийг албан байгууллагуудаас авах борлуулалтын авлага эзэлж байна.

2013-2015 оны авлагын судалгааг хүснэгтээр харуулбал:

							/мян.төг/
Д/д	Авлагын төрөл	2013 он	2014 он	2015 он	2014 оны өөрчлөлт	2015 оны өөрчлөлт	
1	Дотоод байгууллагуудаас авах авлага	2,911.3	716.0	36.4	-2,195.3	-679.6	

2	Албан газар борлуулалт	1,149.4	13,519.6	77,023.0	12,370.2	63,503.4
3	Айл өрхөөс авах авлага	1,771.9	2,602.4	5,113.5	830.5	2,511.1
4	Хувь хүмүүсээс авах авлага	28.5	28.5	0.0	0.0	-28.5
5	Ажилтан албан хаагчаас авах авлага		112.5	19.2	112.5	-93.3
6	ААНОАТ-ын урьдчилгаа	461.4	1,111.2	2,656.0	649.8	1,544.7
7	Цалингийн урьдчилгаа			240.0	0.0	240.0
Нийт дүн		6,322.5	18,090.2	84,848.1	11,767.7	66,757.9


Хүснэгтээс харахад: 2014 онд авлага өмнөх оныхоос 11.767.7 мянган төгрөгөөр, 2015 онд авлага өмнөх оноос 66,757.9 мянган төгрөгөөр буюу 4.7 дахин өссөн байна. 2014 онд нийт авлагын 74.8 хувь, 2015 онд 90.8 хувийг тус тус ААНБ-ын авлага эзлэж байна. Айл өрхөөс авах авлага 2015 онд өмнөх оныхоос 96.5 хувиар өссөн байна.

2013-2015 оны өглөгийн судалгааг хүснэгтээр харуулбал:


							/мян.төг/
Д/д	Өглөгийн төрөл	2013 он	2014 он	2015 он	2014 оны өөрчлөлт	2015 оны өөрчлөлт	
1	Дотоод байгууллагуудад өгөх өглөг	4,438.3	15,475.9	18,955.1	11,037.6	3,479.2	
2	Цалингийн өглөг		0.8	0.0	0.8	-0.8	
3	НДШ-ийн өглөг	5,149.4	4,489.3	10,846.3	-660.1	6,357.0	
4	Хувь хүмүүст өгөх өглөг	737.8		663.5	-737.8	663.5	
5	Суутганы өглөг	347.9		1,804.1	-347.9	1,804.1	
6	Хувь хүмүүст өгөх өглөг		22.2	2.8	22.2	-19.3	
7	НӨАТ-ын өглөг			2,486.5	0.0	2,486.5	
8	Нийт дүн	10,673.4	19,988.1	34,758.4	9,314.7	14,770.3	

Хүснэгтээс харахад: 2014 онд өглөг өмнөх оныхоос 87.2 хувь буюу 9,314.7 мянган төгрөгөөр, 2015 онд 14,770.3 мянган төгрөгөөр хувь буюу 74.0 хувиар тус тус өссөн байна. 2014 онд нийт өглөгийн 77.4 хувь, 2015 онд 54.5 хувийг тус тус ААНБ-уудад өгөх өглөг, мөн НДШ-ийн өглөг 2014 онд 22.5 хувь, 2015 31.2 хувийг тус тус эзлэж байна.

2013-2015 оны авлага, өглөгийн өсөлт, бууралтыг графикаар харуулбал



Графикаас харахад: авлага, өглөг жил бүр өсөх хандлагатай боловч авлагаа цаг тухайд нь бүрэн барагдуулж ажиллавал өглөг үүсэхгүй байх боломжтой байна.



2013 онд нийт авлагын 46 хувийг дотоод байгууллагуудаас авах авлага, 18 хувийг албан газрын халаалтын авлага, 28 хувийг айл өрхөөс авах авлага, 7 хувийг ААНОАТ-ын авлага тус тус эзэлж байна.

2014 онд нийт авлагын 4 хувийг дотоод байгууллагуудаас авах авлага, 75 хувийг албан газрын халаалтын авлага, 14 хувийг айл өрхөөс авах авлага, 6 хувийг, ААНОАТ-ын авлага, 1 хувийг ажилтан албан хаагчаас авах авлага тус тус эзэлж байна

2015 онд нийт авлагын 91 хувийг албан газрын халаалтын авлага, 6 хувийг айл өрхөөс авах авлага, 3 хувийг ААНОАТ-ын авлага тус тус эзэлж байна

Энэ нь ААНБ, иргэдээс халаалт, цахилгааны төлбөрийг хугацаанд нь авч барагдуулалгүй авлагыг их хэмжээгээр үүсгэж, төлбөрийн чадваргүй болсонтой холбоотой бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэснийг зөрчсөн байна.

Иймд ААНБ, иргэдээс авах борлуулалтын орлогыг тайлант ондоо багтааж бүрэн төвлөрүүлэх, ажил хариуцсан борлуулалтын байцаагч нарын ажлын хариуцлагыг сайжруулах, өглөг, авлага үүсгэхгүй ажиллах, байгууллагын удирдлагаас хэрэгжүүлэх дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.2 Байгууллагын 2015 оны ашиг, алдагдыг буруу тооцсон байна

Байгууллагын 2014-2015 оны ашиг алдагдлыг тооцохдоо 2014 онд 2,027.5 мянган төгрөгийн, 2015 онд 2,323.9 мянган төгрөгийн үйл ажиллагааны зардал болон үндсэн хөрөнгийн элэгдлийг 26,829.8 мянган төгрөгөөр илүү байгуулан өртөгт оруулан тооцсоноос байгууллагын ББӨ бодит бусаар нэмэгдэж, алдагдалтай гарсан байна.

2013-2015 оны ашиг алдагдлыг хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

Д/д	Үзүүлэлт	2013 он	2014 он	2015 он	2014 оны өөрчлөлт	2015 оны өөрчлөлт
1	Борлуулалтын орлого	148,246.0	180,144.4	255,243.7	31,898.4	75,099.3
2	ББӨ	136,049.1	155,965.7	201,748.4	19,916.6	45,782.7
3	Нийт ашиг	12,196.9	24,178.7	53,495.3	11,981.8	29,316.6
4	Үйл ажиллагааны зардал	33,319.1	50,031.1	58,255.3	16,712.0	8,224.2
5	Үйл ажиллагааны бус орлого		0.0	1,650.0	0.0	1,650.0
6	Үйл ажиллагааны бус зардал	711.6	1,408.8	11,280.3	697.2	9,871.5
7	Тайлант үеийн ашиг алдагдал	-21,833.8	-27,261.2	-14,390.3	-5,427.4	12,870.9

Дээрх хүснэгтээс харахад: 2014 онд борлуулалтын орлого өмнөх оноос 31,898.4 мянган төгрөгөөр өссөн боловч ББӨ-ний өртөг, үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус зардал өссөнөөс шалтгаалж алдагдалтай ажилласан байна.

2015 онд халаалтын үнэ нэмэгдэж, борлуулалтын орлого өссөн боловч алдагдалтай гарсан байна. Энэ нь ашиглалтанд ороогүй үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулж 26,829.8 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тайлант оны өртөгт оруулан тооцоолсноос шалтгаалсан ба уг алдагдал бодит бус алдагдал байна.

Мөн тус онд 10,359.4 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг данснаас хасаж, хөрөнгө акталсны гарзыг тооцож бүртгэж тайлагнаагүй байна.

4.3 Байгууллагын удирдлагын зүгээс санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Тус байгууллага нь 2014-2015 онд дотоод хяналт шалгалт хийх дүрэм, журмаа батлаагүй, дотоод хяналтын ажилтныг томилж ажиллуулаагүй байна.

Мөн аудитаар илрүүлсэн зөрчил, дутагдлуудыг харахад байгууллагын удирдлагаас байгууллагын хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэх дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн гэх үндэслэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16 дугаарзүйлийн батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д. “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд тус байгууллага нь дотоод хяналт шалгалт хийх дүрэм журмаа баталж, дотоод хяналтын ажилтанг томилон ажиллуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 80,867.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба 29,957.1 мянган төгрөгөнд албан шаардлага өгч, 50,910.2 мянган төгрөгөнд зөвлөмж өглөө.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

Зорилт 1 : Талын илч” ОНӨААТҮГ-ын дарга 2014-2015 онд аймаг, сумын Засаг дарга нартай үр дүнгийн гэрээ байгуулан, тухайн тайлант жилийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулж ажиллаагүй ба 2016 онд гурвалсан гэрээ байгуулсан боловч төлөвлөгөөгөө батлуулаагүй байна.

Жил бүр орлогын төлөвлөгөө нь нэмэгдэн батлагдаж байгаа боловч орлогын төлөвлөгөөг жил бүр давуулан биелүүлсэн нь орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүй, үндсэн үйл ажиллагааны орлогоос гадна олж буй бусад орлогыг төлөвлөөгүйтэй холбоотой байна.

Зорилт 2: Тус байгууллага нь жил бүр алдагдалтай ажиллахаар тооцоолсон нь орлого олох боломжит нөөц бололцоогоо дайчлаагүй, байгууллагын үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллаагүйгээс гадна нүүрсний үнэ болон тээврийн хөлс, цахилгааны зардлыг үндэслэлгүйгээр өсгөн тооцоолж, алдагдалтай ажиллахаар төлөвлөсөнтэй холбоотой байна.

Тус байгууллага нь 2014 онд 267,699.4 мянган төгрөгийн зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 202,696.0 мянга, 2015 онд 324,956.5 мянган төгрөгийн зардал төлөвлөж, гүйцэтгэлээр 254,769.3 мянган төгрөгийн зардал гаргасан байна. Тус онуудад төлөвлөсөн зардлаа 21.6-24.5 хувиар хэмнэж ажилласан боловч уг хэмнэлт зарим зардлыг хэт өндөр төлөвлөсөнтэй холбоотой байна.

Зорилт 3: Тус байгууллага нь НББ-ийн үйл ажиллагаанд санхүүгийн програмыг 2012 оны 07 сарын 14-нөөс эхлэн ашиглаж эхэлсэн бөгөөд програмд үндсэн хөрөнгүүдийг бүртгэхдээ анх ашиглалтад орсон хугацаагаар бүртгээгүй, тухайн өдрөөс ашиглаж эхэлснээр оруулснаас үндсэн хөрөнгүүдийн ашиглалтын хугацаа буруу тооцогдсон байна.

Талын-Илч” ОНӨААТҮГ-т 2016 оны байдлаар ашиглалтын хугацаа дууссан 4 төрлийн 7,715.0 мянган төгрөгийн хөрөнгө ашиглагдаж байгаа боловч уг хөрөнгийн ашиглалтын хугацааг нь тогтоож, дахин үнэлгээ хийгээгүй байна.

Тус байгууллага өөрийн хөрөнгөөр худалдаж авсан 8,780.8 мянган төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, данс бүртгэлд тусгахдаа эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.

Тус газар нь НБББББ-ийг өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулж өөрчлөөгүй, шинэчлэгдсэн хууль эрхийн актын өөрчлөлтийг оруулж өгөөгүйгээс үндсэн

хөрөнгийн ашиглалтын хугацаа болон ашиглагдаагүй хөрөнгөнд элэгдэл байгуулсан байна.

Зорилт 4: Тус байгууллага нь 2014 онд 18,090.2 мянган төгрөгийн авлагатай, 19,988.1 мянган төгрөгийн өглөгтэй, 2015 онд 84,848.1 мянган төгрөгийн авлагатай, 34,758.4 мянган төгрөгийн өглөгтэй ажилласан байна.

Тус байгууллага нь 2014-2015 онд дотоод хяналт шалгалт хийх дүрэм, журмаа батлаагүй, дотоод хяналтын ажилтныг томилж ажиллуулаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараахь зөвлөмжийг өгч байна.

Баянтал сумын “Талын-Илч” ОНӨААТҮГ-ын захиралд:

1. Жил бүрийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулж, мөрдөн ажиллах
2. Байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан бодит тооцоо судалгаа, тоон мэдээлэлд үндэслэн орлогыг боломжит хэмжээ, нэр төрлөөр нь төлөвлөн батлуулж, биелэлтийн нь хангаж ажиллах, мөн орлогыг нэр төрлөөр нь үнэн зөв бүртгэж тайлагнаж байх
3. Үйлдвэрлэл, үйл ажиллагааны зардал, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг үнэн зөв тооцоолж байх,
4. Байгууллагын НББББ-т үйлдвэрлэл, үйл ажиллагааны болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, зардлыг холбогдох стандарт, журам, зааврын дагуу тооцох аргачлалын талаар нэмэлт өөрчлөлт оруулах
5. Зардлыг төлөвлөгөөг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан, бодит тоо мэдээнд үндэслэн үнэн зөв төлөвлөж байх
6. Ашиглалтын хугацаа дууссан ашиглаж байгаа хөрөнгүүдийн дахин үнэлгээ хийж, элэгдлийг байгуулах
7. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд илүү тооцсон элэгдлийн зардлыг залруулах үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, байгуулах элэгдлийн хувь хэмжээг тогтоож, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу элэгдлийг үнэн зөв тооцох
8. Үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ холбогдох эрх бүхий байгууллагын зөвшөөрөл авч байх
9. ААНБ, иргэдээс авах борлуулалтын орлогыг тайлант ондоо багтааж бүрэн төвлөрүүлэх, ажил хариуцсан борлуулалтын байцаагч нарын ажлын хариуцлагыг сайжруулах, өглөг, авлага үүсгэхгүй ажиллах, байгууллагын удирдлагаас хэрэгжүүлэх дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах
10. Тус байгууллага нь дотоод хяналт шалгалт хийх дүрэм журмаа баталж, дотоод хяналтын ажилтанг томилон ажиллуулах

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ТАЛЫН ИЛЧ
ОРОН НУТГИЙН ӨМЧИГ ҮЙЦДВЭРИЙН ГАЗАР
42030 Баянтал сум, Говьсүмбэр аймаг

2016.12.07 № 133
танай _____-ны № _____-т

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Манай байгууллагын 2014-2015 оны санхүүгийн зарим үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд оруулах саналгүй болно.

ЗАХИРАЛ  А.БАТЖАРГАЛ

Ц.Батсайхан-З.
Монгол улсын
хөгжлийн
2016/12/15

D:/Бичиг хэрэг/Blank/ A-5